ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 23 өдөр Дугаар А/39 Улиастай

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй
төрөлт, гэрийн эндэгдлийг магадлан хэлэлцэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйл 33.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.1, MNS 5377:2004 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/503 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тав хүртэлх насны эмнэлгийн нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журмыг нэгдүгээр, Тав хүртэлх насны эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн журмыг хоёрдугаар, Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүргийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар ханган хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс /Д.Бямбаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалыг мөрдөж ажиллахыг харъяа эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 15 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА Ч.ДЭМЧИГСҮРЭН

ИЮЕ0002

/My.doc.tushaal-2019/

62192477

Эрүүл мэндийн газрын даргын.....2019 оны
..12 дугаар сарын..28.. ны өдрийн.A/39
дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ИЮЕ0002

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журам

НЭГ: Ерөнхий зүйл

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлт, гэрийн эндэгдлийн тохиолдол бүрт тусламж үйлчилгээг чанартай, зөв үзүүлсэн эсэхийг хянаж, хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм. Байгууллагын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь зөв боловч хэрэгжих арга зам нь тодорхой бус, мэдлэг, ур чадвар хангалтгүй, гардан ажилбар буруу хийсэн, биеийн байдлыг үнэлж чадаагүй, тушаал, шийдвэр, стандарт, заавар, журам, удирдамж мөрдөөгүй зэрэг удирдлага, зохион байгуулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээний болон эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварын алдаа дутагдлыг дүгнэж, засаж залруулах, шуурхай арга хэмжээ авах, давтагдахаас сэргийлэх тогтолцоог эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлнэ.

ХОЁР: Зорилго

Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлт, гэрийн эндэгдэлд нөлөөлж буй шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, цаашид авах арга хэмжээ, зохион байгуулах ажлыг төлөвлөж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх зорилготой.

ГУРАВ: Магадлан хэлэлцэх зөвлөлийн ажиллах журам

3.1. Эрүүл мэндийн байгууллагын шатлал бүрт эмнэлэгт эндсэн тав хүртэлх насны хүүхдийн тохиолдлыг магадлан хэлэлцэхдээ эмгэг судлалын дүгнэлт гарснаар эмнэлзүйн хурлыг Эрүүл мэндийн газартай зөвшилцөн холбогдох мэргэжилтний төлөөлөлийг оролцуулан тухай бүрд нь хийж материалыг эрүүл мэндийн газарт ажлын 3 хоногийн дотор цаасан болон цахим хэлбэрээр илгээнэ.

3.2 Эрүүл мэндийн газар нь хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хийнэ.

3.1. Өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэгт болон тухайн нутаг дэвсгэрт тав хүртэлх насны эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхэд, амьгүй төрөлтийн тохиолдлыг Эрүүл мэндийн газарт магадлан хэлэлцэнэ.

3.2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвд эндсэн тав хүртэлх насны хүүхэд, амьгүй төрөлтийн тохиолдлыг байгууллага бүрт магадлан хэлэлцэнэ.

3.3. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

- ✓ Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүгнэлт гаргана;
- ✓ Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж, бууруулах талаар шийдвэр гаргана;
- ✓ Оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт хийж, зөвлөмж гаргана;
- ✓ Дүгнэлтэд үндэслэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тогтоож, цаашид зохион байгуулах ажлыг төлөвлөнө;
- ✓ Өмнө нь гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлнэ;

3.4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцсэн хурлын тэмдэглэл, зөвлөмж, шийдвэрийг хувилан, хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор Эрүүл мэндийн газар, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-ийн Тандалт судалгааны албанд албан бичгийн хамт хүргүүлнэ.

202

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны
12 дугаар сарын 22 ны өдрийн А/129
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ИЮЕ0002

ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ЭМНЭЛГИЙН БУС НӨХЦӨЛД ЭНДСЭН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг. Тав хүртэлх насны эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийг мэдээлэх

1.1. Түргэн тусламжийн дуудлагаар очсон буюу анх мэдсэн эмч тав хүртэлх насны **эмнэлгийн бус нөхцөлд эндсэн** хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг байгууллагын удирдлагад мэдээлж, тухайн байгууллага 24 цагийн дотор аймгийн Эрүүл мэндийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистикч эмчид мэдэгдэнэ.

1.2. Тав хүртэлх насны **эмнэлгийн бус нөхцөлд эндсэн** хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг 7 хоногийн Мягмар гараг бүрт Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд сар бүрийн 2-3-нд статистик мэдээллийн урсгалын дагуу мэдээлнэ.

Хоёр. Эмгэг судлалын шинжилгээнд оруулах

2.1. Цогцост анхны үзлэг хийсэн эмч гадны нөлөө байгаа эсэхэд дүгнэлт өгнө.

2.2. Тухайн эмч эндсэн хүүхэдтэй холбоотой эрүүл мэндийн бичиг баримтыг ар гэрийнхнээс нь авч холбогдох байгууллага (өрх, сумын эрүүл мэндийн төв...гэх мэт)-д хүлээлгэн өгнө.

2.3. Тухайн тохиолдол нь гадны нөлөөтэй байвал цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ, гадны нөлөөгүй гэж үзсэн тохиолдолд оршин буй нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллагын цогцос хадгалах газарт түргэн тусламжийн машинаар зөөвөрлөн хүргэнэ.

2.4. Тухайн тохиолдол нь гадны нөлөөгүй бол эмгэг судлалын шинжилгээг эмгэг судлаач эмч хийх ба гадны шалтгааны улмаас нас барсан, гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагын шийдвэрээр Шүүхийн шинжилгээний албаны шүүх эмнэлгийн шинжээчээр хийлгэнэ.

2.5. Хөдөө орон нутагт эндсэн тохиолдолд тухайн байгууллага нь аймгийн нэгдсэн эмнэлэгт дуудлага өгч, эмгэг судлалын шинжилгээг хийлгүүлнэ.

2.6. Нас барснаас хойш 24 цагийн дотор эмгэг судлалын шинжилгээнд хамруулна.

2.7. Эмгэг судлалын шинжилгээнд эмгэг судлаач эмчээс гадна хариуцсан эмч, тухайн байгууллагын чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн, шаардлагатай тохиолдолд бусад холбогдох эмч, мэргэжилтнүүд оролцоно.

2.8. Эмгэг судлаач эмч **эмнэлгийн бус нөхцөлд эндсэн** эндэгдэлтэй холбоотой бүх баримттай танилцаж, эмгэг судлалын шинжилгээний дүгнэлтийг хуанлийн 21 хоногийн дотор гаргаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ.

2.9. **Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн** эндэгдлийг нас баралтыг мэдээлэх статистик журамд заасны дагуу мэдээлнэ.

Гурав. Эмнэлзүйн хурал хийх

3.1. Бүрдүүлэх материал

- Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
- 2 хүртэлх насны хүүхэд бол эхийн жирэмсний хяналтын карт
- ХӨЦМ-ийн үзлэгийн маягт
- Хүүхдийн диспансерийн хяналтын карт
- Амбулаторийн карт, цахим бүртгэл
- Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилтийн бүртгэл
- Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авч байсан холбогдох бусад материалууд (яаралтай тусламжийн хуудас, төрөлтийн, нярайн болон өвчний түүхийн хуулбар)

3.2. Эмгэг судлалын эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор байгууллагад суурилсан эмнэлзүйн хурлыг Эрүүл мэндийн газрын холбогдох төлөөлөл, эмгэг судлаач эмчийг оролцуулан зохион байгуулна.

3.3. Хурлаар **эмнэлгийн бус нөхцөлд эндсэн** эндэгдлийн шалтгаан, хожимдол, үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж гарсан байна.

3.4. Хурлын шийдвэр, холбогдох материалыг харъяа магадлан хэлэлцэх зөвлөлд хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор хүргүүлнэ.

Дөрөв. Хариуцлага, эргэх холбоо

4.1 Эмчилгээ үйлчилгээний дутагдал бол шалтгааныг судлан өөрийн зардлаар дахин суралцуулах ба эмч мэргэжилтнүүдээ чадавхижуулах саналыг тухайн байгууллагад хүргүүлнэ

4.2 Хүүхдийн эндэгдлийг хугацаанд нь мэдээлээгүй, аудит хурлаа хугацаанд нь хийж материалаа бүрэн ирүүлээгүй, эмнэлгийн анхан шатны баримт бичиг үнэн зөв хөтлөөгүй болон засварласан албан тушаалтанд холбогдох эрх зүйн актаар арга хэмжээ авна.

4.3 Хурлын шийдвэрийг холбогдох эмч мэргэжилтнүүд заагдсан хугацаанд хийж гүйцэтгэн дараагийн хуралд тайлагнана.

204

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны
12 дугаар сарын 23 ны өдрийн А/139
дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ИЮЕ0002

Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг

Нэг. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

1.1. Аймгийн Эрүүл мэндийн газар

Зөвлөлийн дарга;	Аймгийн Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга;	Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн *(хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед)* Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн *(эрт нярайн эндэгдэл, амьгүй төрөлт хэлэлцэх үед)*
Гишүүд;	Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн /тухайн эмнэлгийн чанарын албаны дарга, менежер/ НЭМТ-ийн дарга Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Статистикч эмч, мэргэжилтэн Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтэн

Хоёр. Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг

1. Зөвлөлийн дарга эндэгдлийн хурлыг удирдан зохион байгуулах, дэгийг батлах, шийдвэрт хяналт тавих,
2. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эндэгдэлтэй холбогдох материалыг хүлээн авах, хурлын зар хүргүүлэх, хурал зохион байгуулах, холбогдох байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх, бэлтгэл ажлыг хангуулах
3. Чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн нь тусламж үйлчилгээний эрсдлийг үнэлэх, алдаанаас суралцах, дахин давтахаас сэргийлэх талаар санал оруулах, мэдээлэл бэлтгэх,
4. Эрүүл мэндийн газрын хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь хэрэгжиж буй хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, тогтолцоотой холбоотой асуудлаар ЭМЯ-нд санал хүргүүлэх,

5. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан дарга, мэргэжилтэн нь эндэгдэлд хүргэсэн нийгэм, биологийн хүчин зүйлсийг үнэлэх, түүнийг таслан зогсооход салбар хоорондын уялдааг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал гаргах, хэрэгжүүлэх,
6. Статистикч эмч нь анхан шатны бичиг баримт, бүртгэл мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллах ба тухайн байгууллагын эндэгдэлтэй холбогдох материалыг хянан бүртгэлжүүлэн нарийн бичигт хүргэх
7. Гишүүд нь хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллана.

206

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны
...12... дугаар сарын...23...-ны өдрийн ...A/129...
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

Үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлал

Нэг. Тодорхойлолт

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойшхи хугацаанд 500 гр-аас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн илрэхгүй байвал амьгүй төрөлтөд тооцно.

Нярай үе: Төрсөн цагаас эхэлж төрсний дараах 28 бүтэн хоног дуусах хүртэл үргэлжилдэг хугацаа.

Перинатал үе: Жирэмсний бүтэн 22 долоо хоног (154 өдөр)-с эхэлж (энэ үед ургийн жин 500 грамм байна) төрсний дараах 7 хоног хүртэл үргэлжилдэг хугацаа.

Нярайн эндэгдэл: Амьдралын эхний бүтэн 28 хоног дотор нярайн эндэгдэл.

Нярайн эрт үеийн эндэгдэл: Төрсний дараах эхний 7 хоног доторх эндэгдэл.

Нярайн хожуу үеийн эндэгдэл: Төрсний дараах 7 дахь хоногоос хойш боловч бүтэн 28 хоног дуусах хүртэлх хугацаанд тохиолдсон эндэгдэл.

Нэг хүртэлх насны (нялхсын) хүүхэд: 0-364 хоногтой хүүхэд.

Тав хүртэлх насны хүүхэд: 0-4 нас, 364 хоногтой хүүхэд.

Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэл: Хүүхэд эмнэлгээс бусад газарт эндсэн тохиолдол бүрийг хэлнэ.

Хоёр. Үзүүлэлт тооцох аргачлал

2.1. Амьгүй төрөлтийн түвшин:

Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн амьгүй төрөлтийн тоог 1000 нийт төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Амьгүй төрөлтийн тоог 1000 нийт төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Амьгүй төрөлтийн түвшин} = \frac{\text{Амьгүй төрөлтийн тоо} * 1000}{\text{Нийт төрөлтийн тоо}}$$

2.2. Нярайн эндэгдлийн түвшин: Төрсний дараах 28 хоногийн дотор эндсэн хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 28 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

2.2.1. Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин: Төрсний дараах эхний 7 хоног дотор эндсэн нярайн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн **эрт үеийн** эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 7 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

2.2.2. Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин: Төрсний дараах 7-28 хоног дотор эндсэн нярайн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нярайн **хожуу үеийн** эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нярайн хожуу үеийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Төрсний дараах 7 – 28 хоногийн дотор эндсэн нярайн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

2.3. Нэг хүртэлх насны хүүхдийн (нялхсын) эндэгдлийн түвшин: Тайлангийн жилд эндсэн 1 хүртэлх насны хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нас барсан 1 хүртэлх насны хүүхдийн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$

2.4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: Тайлангийн жилд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулсан үзүүлэлт.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөд харьцуулан доорх томъёог ашиглан тооцно.

$$\text{Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин} = \frac{\text{Нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн тоо} * 1000}{\text{Амьд төрөлтийн тоо}}$$